

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### *Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл*

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг Олон Улсын Атомын Энергийн Агентлагийн гишүүн орнуудын санаачилгаар 1994 онд баталж, 1996 оны 10 дугаар сарын 24-нд хүчин төгөлдөр болсноос хойш одоогийн байдлаар 96 улс нэгдэн орсон байна.

Конвенцын зорилго нь олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар дэлхий дахинд цөмийн аюулгүй ажиллагааны дэглэмийг ханган тогтвортой байдлыг сахих, цөмийн төхөөрөмжөөс үүсэх ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор болзошгүй цацрагийн ослын үед үр дүнтэй хариу арга хэмжээ төлөвлөх, хэрэгжүүлэх, цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд сөрөг үр дагаврыг багасгахад оршино. Энэхүү конвенц нь цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагааг хангахад үйлчилнэ.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улс цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах үйл ажиллагааг цөмийн аюулгүй байдлын олон улсын хэм хэмжээ, шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 06 дугаар сарын 19-ны өдөр баталсан “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” 60 дугаар тогтоолд Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенцод нэгдэн орохыг Засгийн газарт даалгасан.

Улсын Их Хурлын 2015 оны 60 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг Улсын Их Хурлаар соёрхон батлуулах талаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр шийдвэрлэсэн.

Улмаар Засгийн газраас тус конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар конвенцод нэгдэн орох асуудлыг хэлэлцээд дэмжсэн санал, дүгнэлт гарсан.

2024 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дараа Монгол Улсын Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбоотойгоор хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулж, Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу өргөн мэдүүлж байна.

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

### *Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл*

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 06 дугаар сарын 19-ны өдөр баталсан “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” 60 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт **“Цөмийн аюулгүй байдлын тухай 1994 оны конвенц**, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцийн 2005 оны нэмэлт, өөрчлөлтийн тухай протокол болон Цөмийн бага хэмжээний шинэчилсэн протоколд тус тус нэгдэн орох” арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Иймд, Монгол Улсын Улсын Их Хурлын 2015 оны 60 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсруулав.

#### **1. Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага**

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай 1994 оны конвенцыг Олон улсын атомын энергийн агентлагийн гишүүн орнуудын санаачилгаар 1994 онд баталж, 1996 оны 10 дугаар сарын 24-нд хүчин төгөлдөр болсноос хойш одоогийн байдлаар 96 улс нэгдэн орсон байна.

Монгол Улс нь цөмийн байгууламжгүй хэдий ч цөмийн түлшний циклийг бүхэлд нь хэрэгжүүлдэг, цөмийн зэвсэгтэй 2 их гүрний дунд оршиж байдаг газар зүйн онцлогтой. Монгол Улстай хиллэдэг ОХУ, БНХАУ-ын цөмийн байгууламжийн аюулгүй байдал нь тухайн улсын хяналтын байгууллага, Олон улсын атомын энергийн агентлаг (“ОУАЭА”)-ийн нарийн чанд хяналтанд байдаг хэдий ч болзошгүй ослын үед манай улсад хил дамнасан цацраг идэвхт бохирдол үүсгэх эрсдэлтэй байна.

Цөмийн ослоос үүссэн хил дамнасан цацраг идэвхт бохирдлын тархалт нь ослын зэрэглэлээс хамаарч хэр хэмжээний радиуст тархах нь харилцан адилгүй байдаг. Тухайлбал, 1986 онд тохиолдсон Чернобылийн цөмийн эрчим хүчний станцын ослын үед Улаанбаатар хот болон зарим аймгийн агаарын тунадас, тоосонцрын дээжид хийсэн цацрагийн хэмжилтээр цацраг идэвхт бодис 9 дэх хоногтоо манай оронд бүртгэгдэж, байгалийн дэвсгэр түвшний хэмжээг тодорхой хугацаанд нэмэгдүүлсэн ч хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх хэмжээнд хүрээгүй байсан.

Монгол Улсын Их хурлын 2024 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.7-д “Ураны нөөцийг түшиглэн атомын цахилгаан станц барих бодлого хэрэгжүүлж суурь судалгааг хийнэ” гэж тусгасан бөгөөд ОУАЭА-аас цөмийн эрчим хүч барьж байгуулахаар төлөвлөж буй 27 улсын жагсаалтад Монгол Улсыг оруулсан байна.

ОУАЭА-аас 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Монгол Улсын Цөмийн энергийн комисст ирүүлсэн албан бичигт Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол 2005 онд шинэчлэгдсэнээс хойш Монгол Улсын Засгийн

газраас холбогдох арга хэмжээг аваагүйгээс үүдэн цөмийн технологийг энхийн зорилгоор ашиглаж байгаа баталгааны дүгнэлтийг гаргах боломжгүй болохын зэрэгцээ эрүүл мэнд, аж үйлдвэр, хөдөө, аж ахуй, байгаль орчин, цацрагийн аюулгүй ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсээд байна.

## **2. Дэлхийн улс орнууд конвенцод нэгдэн орсон байдал**

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцод 2024 оны 09 дүгэр сарын 18-ны өдрийн байдлаар 96 орон нэгдэн орж, 65 улс гарын үсэг зурсан байна.

## **3. Конвенцын зорилго, зохицуулах зүйл, хамрах хүрээ**

Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенц нь 4 бүлэг 35 зүйлтэй. Конвенцын хүрээнд хэлэлцэн тохиролцогч талуудын хүлээх үүрэг, хариуцлагыг дараах байдлаар тодорхойлсон ба хэлэлцэн тохиролцогч тал бүр өөрийн үндэсний хууль тогтоомжийн хүрээнд конвенцын дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн орчин, хяналтын болон захиргааны арга хэмжээ, шаардлагатай бусад алхмыг авч хэрэгжүүлнэ.

Конвенцын зорилго нь үндэсний арга хэмжээ болон олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар дэлхий дахинд цөмийн аюулгүй ажиллагааны дэглэмийг ханган тогтвортой байдлыг сахих, цөмийн төхөөрөмжөөс үүсэх ионжуулагч цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам, хүрээлэн буй орчныг хамгаалах зорилгоор болзошгүй цацрагийн ослын үед үр дүнтэй хариу арга хэмжээ төлөвлөх, хэрэгжүүлэх, цацрагийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд сөрөг үр дагаврыг багасгахад оршино. Энэхүү конвенц нь цөмийн байгууламжийн аюулгүй ажиллагааг хангахад үйлчилнэ.

Цөмийн аюулгүй ажиллагааг хангахад тавигдах үндэсний шаардлага, дүрэм, журмыг бий болгох, цөмийн байгууламжийг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр ажиллуулах болон тусгай зөвшөөрөлгүйгээр ажиллуулахыг хориглосон тогтолцоог бүрдүүлсэн байх, холбогдох дүрэм, журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага (тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, өөрчлөх, эсхүл хүчингүй болгох)-ыг хангаж байгаа эсэхийг тогтоох зорилгоор цөмийн байгууламжид хяналт шалгалт, үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлсэн байх шаардлагатай байдаг.

Хэлэлцэн тохиролцогч талууд цөмийн байгууламжтай шууд холбоотой үйл ажиллагаа эрхэлж буй бүх байгууллага цөмийн аюулгүй ажиллагааг тэргүүн ээлжид хангах бодлого боловсруулж, мөрдөх нөхцөлийг хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд: Цөмийн байгууламжийн үйл ажиллагааны бүхий л үе шатанд тухайн байгууламжид ажиллагсад болон хүн амд үзүүлэх цацрагийн шарлагын хэмжээг байж болох хамгийн бага түвшинд байлгах нөхцөлийг хангах, цөмийн байгууламжийн биет байдал, түүний үйл ажиллагаа нь зураг төсөл, аюулгүй ажиллагааны холбогдох үндэсний шаардлагууд болон үйл ажиллагааны нөхцөл, хориг хязгаарлалтад нийцэж буй эсэхийг судалгаа шинжилгээ явуулах, туршилт, шалгалт хийх замаар тогтоож баталгаажуулах, цацрагийн осолд өртөх магадлалтай байвал цөмийн байгууламжийн хөрш зэргэлдээ орших өөрийн хүн ам болон эрх бүхий байгууллагуудыг ослын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө, хариу арга хэмжээний талаар холбогдох мэдээллээр хангахад чиглэсэн зохих арга хэмжээг авах зэрэг болно.

Хэлэлцэн тохиролцогч талууд конвенцын хүрээнд хүлээсэн үүргийнхээ хэрэгжилтийн тайланг 3 жилд нэг удаа хэлэлцдэг бөгөөд тайлан хэлэлцэх хуралд зөвхөн тус конвенцод нэгдэн орсон улс орнууд оролцох эрхтэй. Хэлэлцэн тохиролцогч тал бүр хурлын өмнө конвенцын дагуу хүлээсэн үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн арга хэмжээний талаарх тайланг хэлэлцүүлэхээр ОУАЭА-т хүргүүлнэ.

Тайлан хэлэлцэх хурлаар цөмийн эрчим хүчний хөтөлбөртэй хэлэлцэн тохиролцогч талуудын ирүүлсэн үндэсний тайланг хянан үзэх боломжийг бүх хэлэлцэн тохирогч талуудад олгож, цөмийн эрчим хүчний станцуудын аюулгүй ажиллагааг хангах үндэсний зохицуулалт нь олон улсын стандартад нийцэж буйг баталгаажуулдаг. Хяналтын үйл явц нь туршлага солилцох, хамтран суралцах хүрээнд хэрэгждэг тул энэ нь Цөмийн эрчим хүчний хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хэлэлцэн тохирогч талуудад онцгой ач холбогдолтой юм.

Хэлэлцэн тохиролцогч талууд тайлан хэлэлцэх хуралд заавал оролцох бөгөөд тухайн талыг төлөөлөн нэг төлөөлөгч болон түүнтэй адилтгах бусад төлөөлөгч, мэргэжилтэн, зөвлөхийг оролцуулсан багийг томилж оролцуулна. Тайлан хэлэлцэх хурлаар хэлэлцэн тохиролцогч талууд хурлаар хэлэлцсэн асуудал болон хүрсэн үр дүн, дүгнэлтийг тусгасан баримт бичгийг батлах ба тухайн баримт бичгийг олон нийтэд нээлттэй байлгана.

Үндэсний тайлан боловсруулахтай холбоотой тухайн улс үндэсний хэмжээнд үйл ажиллагааны зохион байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэх, конвенцын зүйл заалт тус бүрийн хүрээнд тайлан, мэдээлэл гаргаж өгөхөд оролцох үүрэг бүхий үндэсний эрх бүхий байгууллагуудыг тодорхойлох шаардлагатай. Конвенцын 5 дугаар зүйлд заасны дагуу хүргүүлэх тайлангийн хэлбэр, бүтцийн талаарх зааварчилгаа, тайлан хүргүүлэх огноо зэргийг тодорхой болгоно.

Конвенцын 32 дугаар зүйлд заасны дагуу Хэлэлцэн тохиролцогч аливаа тал энэхүү конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Санал болгосон нэмэлт, өөрчлөлтийг тайлан хэлэлцэх хурал, эсхүл ээлжит бус хурлаар хэлэлцэнэ.

Конвенцын 30 дугаар зүйлд заасны дагуу энэхүү конвенцод гарын үсэг зурсан тухай болон түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, эсхүл нэгдэн орсон тухай батламж жуух бичгийг хүлээн авсан тухай конвенцын эх хадгалагчид хүргүүлнэ.

#### **4. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа**

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйлд “Олон Улсын Атомын Энергийн Агентлагаас 1994 онд баталж, 1996 онд хүчин төгөлдөр болсон Цөмийн аюулгүй ажиллагааны тухай конвенцыг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах зохицуулалтыг тусгав.

#### **5. Хуулийн төсөл батлагдсанаар хүлээгдэж буй үр дүн**

Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах үйл ажиллагааг цөмийн аюулгүй ажиллагааны олон улсын хэм хэмжээ, шаардлагын дагуу нийцүүлэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Шинээр барьж буй болон үйл ажиллагаа явуулж буй цөмийн байгууламж нь түүний ойр орчимд байх хөрш зэргэлдээ улсын нутаг дэвсгэрт нөлөөлж болзошгүй учир тухайн талтай зөвлөлдөх, хүсэлт гаргасан тохиолдолд цөмийн байгууламжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авах замаар өөрийн нутаг дэвсгэр дээр үүсэж болзошгүй гадны нөлөөллийг тооцох, аюулгүй ажиллагааны үнэлгээг хийх, хил дамнасан ослын үед авах арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулах, хариу арга хэмжээ авах нөхцөл бүрдэх юм.

Ингэснээр өөрийн орны хүн ам, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, аюулгүй байдлыг хангах боломж бүрдэнэ.

Цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглахад цацрагийн сөрөг нөлөөллөөс хүн ам, нийгэм, хүрээлэн буй орчныг хамгаалах хяналтын тогтолцоо бий болох, шаардлагатай тохиолдолд олон улсын хамтын ажиллагааны хүрээнд техникийн дэмжлэг туслалцаа авах боломжтой болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР